

Мөнхийн ач холбогдолтой сонголтууд, 1-р хэсэг



Энэ үдшийн миний зорилго бол энэ амьдрал нь *та нарын* хувьд ямар амьдралаар мөнхөд амьдрахаа шийдэх цаг мөч гэдгийг ойлгож байгаа эсэхэд санаа тавих явдал юм. Энэ амьдрал бол та нарын “Бурхантай уулзахаар бэлтгэх” цаг үе юм [Алма 12:24; 34:32-ыг үзнэ үү]. . . .

Та нарын одоо сонгох зөв шударга сонголт бүр мөнх бус амьдралд ихээхэн ашиг тус авчрах болно. Түүнчлэн мөнх бус амьдралдаа хийсэн зөв шударга сонголт бүр чинь төсөөлшгүй мөнхийн ашиг тусыг өгөх болно. Хэрэв та нар Бурхантай гэрээ байгуулахыг сонгож, тэдгээр гэрээндээ итгэлтэй байвал, та нарын “[тэргүүнд] алдар суу үүрд мөн үргэлж мөнхөд нэмэгдэх болно” [Абрахам 3:26]. . . .

Дайсан чамайг маргаашийн тухай, тэр дундаа мөнх амьдралын талаар бодуулахыг хүсдэггүй нь мэдээж. Гэсэн ч мөнх бус амьдралын сорилт бэрхшээл, боломжуудын талаар мэдлэггүй, гэнэн байж болохгүй. Тиймээс та нар ирээдүйн аялалдаа бэлтгэхэд туслах гурван суурь үнэнийг ойлгох хэрэгтэй. . . .

Нэгдүгээрт: Өөрсдийгөө хэн болох талаарх үнэнийг мэдэж ав. Энэ орой Их Эзэн та нарт хандан шууд ярьж байсан бол Түүний хийх эхний зүйл нь та нарын жинхэнэ мөн чанарыг ойлгуулах явдал байх байсан. Хайрт найзууд минь, та нар бол Бурханы хүүхэд гэдэг нь чухамхүү үнэн зүйл юм шүү. Та нар “Би Бурханы хүүхэд” [Дуулал, ду. 301] дууллын үгийг сурсан үеэсээ л энэ үнэнийг дуулсаар ирсэн. Харин энэ мөнхийн үнэн та нарын зүрхэнд сийлэгдсэн үү? Уруу таталтыг даван туулахад энэ үнэн та нарт тусалсан уу?

Та нар энэ үнэнийг тэнгэрлэг үнэн гэхээсээ илүүтэй уриа лоозон мэт хүлээн авсан байх вий гэж би эмээж байна. Тиймээс та нар өөрсдийгөө хэн гэж бодох нь та нарын цаашдын шийдвэр бүрд нөлөөлөх болно. . . .

. . . *Та хэн бэ?*

Юуны түрүүнд та бол Бурханы хүүхэд.

Хоёрдугаарт: Сүмийн гишүүний хувьд та бол гэрээний хүүхэд. Гуравдугаарт: Та бол Есүс Христийн шавь юм.

Өнөө орой би та нараас хамгийн чухал, өөрчлөгдөшгүй энэ гурван таних тэмдгийг өөр ямар ч тэмдгээр *орлуулахгүй* байхыг гуйж байна. Хэрэв орлуулах аваас та нарын өсөлт хөгжил удааширч, мөнхийн өсөлт хөгжлөөс ангид байх нэгэн хэвийн нөхцөл байдалд та нар орох болно. . . .

Мэдээж, та нарын хувьд маш чухалд тооцогдох олон таних тэмдэг бий. Намайг буруугаар бүү ойлгоорой. Би бусад ялгарах шинж тэмдэг, загвар шийдлийг ач холбогдолгүй гэж хэлээгүй. Би зөвхөн өөр ямар ч шинж тэмдэг “Бурханы хүүхэд,” “гэрээний хүүхэд,” “Есүс Христийн шавь” гэсэн эдгээр гурван өөрчлөгдөшгүй загварын *урдуур орох, орлох, үгүй болгох* ёсгүй гэж хэлж байгаа юм.

Эдгээр үндсэн гурван загвартай нийцэхгүй аливаа онцлог шинж эцэстээ та нарын урмыг хугалах болно. Бусад таних тэмдэг яваандаа та нарын урмыг хугалдаг болох ба тэдгээр нь та нарыг Бурханы селестиел хаант улсад мөнх амьдрал өөд чиглүүлэх хүч чадалгүй юм. . . .

Үүнийг мартаж болохгүй. Та нарт тэнгэрлэг чадавх бий. Шаргуу эрэл хайгуулын үр дүнд Бурхан та нарт хэн болж чадахыг чинь зэрвэс харуулах болно. (Рассэлл М.Нэлсон, “Мөнхийн ач холбогдолтой сонголтууд” [Залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт, 2022 оны 5-р сарын 15], broadcasts.ChurchofJesusChrist.org)